

ASSESSING THE FINANCIAL SECTOR'S ROLE IN THE ECONOMY THROUGH INPUT–OUTPUT MULTIPLIERS

Enkh-Amgalan Byambajav¹

Abstract: The financial sector has become an increasingly influential component of national economic performance, with its impact expanding steadily over time. Quantifying this influence is essential for policymakers, as it enables them to incorporate the systemic importance of the financial sector into evidence-based decision-making. Comparative analysis of sectoral contributions shows that, following mining, transportation, and trade, the financial sector has grown rapidly and is expected to remain a major driver of economic activity in the future. Against this backdrop, the present study focuses on the financial sector and applies Input–Output table multiplier analysis to assess its effects. The research draws on the Input–Output table published by the National Statistics Committee in 2019, supplemented by calculations provided by the Asian Development Bank up to 2022.

Keywords: Financial sector, Input-Output table, multipliers

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ САЛБАР ХООРОНДЫН ТЭНЦЛИЙГ АШИГЛАН ШИНЖЛЭХ НЬ

Хураангуй: Санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөө жил бүр нэмэгдэж байна. Иймд энэхүү нөлөөлөл нь хэр хэмжээтэй байгааг тодорхойлон харуулж чадвал бодлого гаргагчдын хувьд шийдвэр гаргалтдаа Санхүүгийн салбарын нөлөөллийг харгалзан үзэх боломжтой болох юм. Салбаруудын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг харвал Уул уурхайн салбар, Тээврийн салбар, Худалдааны салбарын дараагаар Санхүүгийн салбарын эзлэх хувь эрчимтэй тэлж байна. Цаашид ч эдгээр салбаруудын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл өндөр байхаар байгаа тул энэ судалгааны ажилд Санхүүгийн салбарыг онцлон авч Салбар хоорондын тэнцлийн үржүүлэгчийн шинжилгээг хийсэн болно. Үндэсний Статистикийн Хорооноос 2019 онд гаргасан салбар хоорондын тэнцэлд тулгуурлан Азийн хөгжлийн банкнаас 2022 он болгож өргөтгөсөн салбар хоорондын тэнцлийн тооцоог энэхүү судалгааны ажилд авч ашигласан болно.

Түлхүүр үгс: Санхүүгийн салбар, Салбар хоорондын тэнцэл, үржүүлэгч

¹ Business School, National University of Mongolia, NISS contract researcher.
(E-mail): enkhamgalan@num.edu.mn

УДИРТГАЛ

Монгол Улсын эдийн засагт салбар бүрийн эзлэх хувийн жин ихээхэн ялгаатай байгаа бөгөөд үүнээс шалтгаалаад эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмэр нь хэлбэлзэл ихтэй байна. Уул уурхайн салбараас хамаарал өндөртэй, төрөлжилт багатай байгаа өнөө үед эдийн засгийг төрөлжүүлэхийн тулд бусад салбаруудыг хөгжүүлэх, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг шинжлэх шаардлагатай юм. Энэ агуулгын хүрээнд Санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг Салбар хоорондын тэнцлийн загварыг ашиглан судалж, үр дүнг тодорхойлсон.

Санхүүгийн салбар нь орчин үеийн эдийн засгийн тогтолцоонд голлох байр суурь эзэлдэг бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн хэрэглээ, хөрөнгө оруулалт зэрэг бусад бүх салбарын үйл ажиллагаанд шууд болон дам нөлөөлөл үзүүлдэг. Санхүүгийн зуучлал, хөрөнгийн зах зээл, даатгалын үйлчилгээ зэрэг нь эдийн засгийн бүтцийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ макро эдийн засгийн өсөлт, салбар хоорондын харилцан хамаарлыг тодорхой хэмжээгээр зохицуулдаг. Иймээс санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөг тоон аргаар шинжлэх нь бодлого боловсруулагчид, судлаачид, олон улсын байгууллагуудад чухал ач холбогдолтой асуудал болж байна. Салбар хоорондын тэнцлийн шинжилгээ нь эдийн засгийн бүтэц, салбар хоорондын урсгал, бодлогын нөлөөг дамжуулах механизм, үржүүлэгчийн нөлөөг тооцох оновчтой арга бөгөөд санхүүгийн салбарын системийн ач холбогдлыг хэмжихэд өргөн хэрэглэгдэж байна. Энэхүү судалгааны ажлын зорилго нь санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөг салбар хоорондын тэнцлийн аргаар шинжлэх олон улсын туршлагыг тоймлон харуулах, онолын болон практик ач холбогдлыг тодорхойлох явдал юм.

Санхүүгийн салбар нь улс орны цусны эргэлтийг илэрхийлэгч үзүүлэлт болохын хувьд эдийн засгийн өсөлт, бууралтыг аль алийг нь тодорхойлох үндсэн гол индикатор болж байдаг. Хэдийгээр уул уурхай, худалдаа, хөдөө аж ахуйн салбар манай улсын үндсэн гол гурван том салбар болж байгаа боловч санхүүгийн салбарын эдийн засгийн салбаруудад эзлэх хувь огцом нэмэгдэж байна.

Олон улсын судалгаанд санхүүгийн салбарын ач холбогдлыг салбар хоорондын тэнцлийн аргаар хэмжих оролдлого өргөн хийгдсэн байдаг.

Sun (2022) дэлхийн салбар хоорондын тэнцлийн өгөгдлийг ашиглан санхүүгийн үйлчилгээ болон даатгалын салбарын системийн ач холбогдлыг Partial Extraction Technique аргаар хэмжиж, шок дамжуулах индекс боловсруулсан бөгөөд томоохон банкнууд болон даатгалын компаниудын эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхойлсон. OECD (2023) салбар хоорондын тэнцлийн шинжилгээний хэрэглээг санхүүгийн үзүүлэлтүүдээр өргөжүүлж, санхүүгийн урсгалын нөлөө, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын дам нөлөөг бодлогын түвшинд үнэлэх боломжийг харуулсан.

Malik ба Schaeffer (2024) салбар хоорондын тэнцлийн арга болон Integrated Assessment Model-ийг хослуулан ашиглаж, санхүүгийн салбарын оролцоог макро эдийн засгийн загварт нэгтгэх боломжийг судалсан бөгөөд энэ нь бодлого боловсруулагчдад эдийн засгийн тогтвортой байдлыг илүү нарийн үнэлэх боломж олгож байгааг онцолсон. Леонтьевийн уламжлалт салбар хоорондын тэнцлийн арга нь анх үйлдвэрлэлийн салбаруудын харилцан хамаарлыг тооцох зорилготой байсан ч орчин үед санхүүгийн үйлчилгээний салбарын оролцоог тооцох чиглэлд өргөн хэрэглэгдэх болсон бөгөөд эдийн засгийн бүтэц, салбар хоорондын урсгалын дам нөлөөг тодорхойлох чухал арга болж байна.

Bunsen ба Finkbeiner (2023) салбар хоорондын тэнцлийн шинжилгээг тогтвортой хөгжлийн судалгаанд ашиглах боломжийг тайлбарлаж, амьдралын мөчлөгийн үнэлгээ, нүүрстөрөгчийн ул мөр, нөөцийн хэрэглээг тооцох зэрэгт салбар хоорондын тэнцлийн арга чухал үүрэгтэйг онцолсон.

Манай улсын хувьд салбар хоорондын тэнцлийг ашигласан судалгааны ажлууд нэлээд хийгдэж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах байдал сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж байна.

Б.Үнэнбат нар (2020) эдийн засгийн 55 салбар хоорондын тэнцлийг 57 салбар болгож өргөтгөн салбар хоорондын тэнцэлд цахилгааны эрчим хүч, дулааны эрчим хүч, бусад дэд салбарууд нь бусад салбарт хэрхэн нөлөөлж буйг шинжлэх боломжийг судлан тодорхойлсон.

Монгол улсын эдийн засагт гүйцэтгэх Оюутолгой төслийн үзүүлсэн нөлөөллийг тооцох судалгааг МУИС-Эдийн засгийн хүрээлэнгээс 2018, 2021 онуудад хийж гүйцэтгэсэн бөгөөд үүнд хөрөнгө оруулалтын өсөлт нь эцсийн хэрэглээгээр дамжин эдийн засгийн салбаруудад хэрхэн хуваарилагдаж байгаа, хэдий хэмжээний ажиллах хүчний түр болон байнгын ажлын байрыг бий болгосон талаар тооцоолж гаргасан байдаг.

Энэхүү судалгааны ажилд Санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал бусад салбаруудтай харьцуулахад ямар байгааг тодорхойлохоос гадна Салбар хоорондын тэнцлийн арга зүйг ашиглан үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн үржүүлэгчийн тооцоог хийж үр дүнг тодорхойлон харуулж дүгнэлт өгсөн болно.

Судалгааны арга зүй, тоон өгөгдөл

Салбар хоорондын тэнцэл нь үйлдвэрлэл, хэрэглээний харилцан уялдааг тоон загварын хэлбэрээр илэрхийлдэг тул санхүүгийн салбарын өсөлт нь бусад салбарын өсөлтөд хэрхэн үржүүлэгчээр дамжин нөлөө үзүүлж байгааг тодорхой харуулна. Иймд судалгааны ажлын үндсэн таамаглал нь санхүүгийн салбар дахь эцсийн эрэлт нэмэгдэхийн хэрээр эдийн засгийн бусад салбаруудад үзүүлэх шууд болон шууд бус

нөлөө өргөжин тэлж, нийт эдийн засаг дахь санхүүгийн салбарын нөлөө ямар түвшинд байгааг тоон утгаар илэрхийлэх явдал юм.

Сонгон авсан хугацаан дахь аль нэг улс, эсвэл бүс нутгийн салбаруудын хоорондын харилцааг шатар хэлбэрийн балансаар тодорхойлон харуулсан хүснэгтийг салбар хоорондын тэнцэл гэдэг.

Салбар хоорондын тэнцлийн арга зүйг анх Орос гаралтай эрдэмтэн Леонтьев боловсруулсан бөгөөд манай улсын хувьд анх 1963 онд өөрийн орны эдийн засгийн салбаруудын хувьд боловсруулснаас хойш тодорхой хугацааны давтамжтай ҮСХ-оос боловсруулж байна. Хамгийн сүүлд албан ёсоор 2019 онд нийт 55 салбарыг хамруулан байгуулсан салбар хоорондын тооцооллыг хийсэн байна.

Салбар хоорондын тэнцэл нь үндсэндээ 4 квадрантаас бүрддэг боловч 1-3 квадрантыг эдийн засгийн судалгаа шинжилгээнд түлхүү ашигладаг.

I квадрант: Нийт эдийн засаг дахь салбар хоорондын эдийн засгийн харилцааг, өөрөөр хэлбэл салбар хоорондын орц, гарц буюу үйлдвэрлэлийн хэлхээ холбоог харуулна.

II квадрант: Салбар бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эцсийн ашиглалт буюу эцсийн хэрэглээ, нийт хөрөнгийн хуримтлал барааг, тусгана.

III квадрант: Шинээр бий болсон нэмэгдэл өртгийг бүрдүүлэгч орлогын хэлбэрээр, эдийн засгийн салбаруудаар харуулна.

Хүснэгт 1. n салбар бүхий салбар хоорондын тэнцлийн хүснэгт

Салбарын №	Завсрын бүтээгдэхүүн				Эцсийн бүтээгдэхүүн				Нийт бүтээгдэхүүн
	1	2	...	n	хэрэглээ	хуримтлал	Экспорт	Бүгд	
1	x_{11}	x_{12}	...	x_{1n}	s_1	k_1	e_1	y_1	x_1
2	x_{21}	x_{22}	...	x_{2n}	s_2	k_2	e_2	y_2	x_2
·	·	·	...	·	·	·	·	·	·
·	·	·	...	·	·	·	·	·	·
n	x_{n1}	x_{n2}	...	x_{nn}	s_n	k_n	e_n	y_n	x_n
	h_1	h_2	...	h_n					$\sum x_i$
	z_1	z_2	...	z_n					
	x_1	x_2	...	x_n					

Салбар хоорондын тэнцлийн шинжилгээг хийхэд хамгийн эхэнд орцын болон гарцын коэффициентийг тооцдог.

Орцын коэффициентүүдийг тооцохдоо салбар хоорондын тэнцлийн баганын өгөгдөл

бүрийг тухайн баганын нийт дүнд харьцуулна. Орцын коэффициент нь нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд аль салбараас хэдий хэмжээний бүтээгдэхүүн, үйлчилгээ болон анхдагч орцын бүрэлдэхүүн хэсгийг зарцуулсныг харуулна.

$$a_{ij} = \frac{x_{ij}}{X_j} \quad (1)$$

Гарцын коэффициентүүдийг тооцоходоо салбар хоорондын тэнцлийн мөрийн өгөгдөл бүрийг тухайн мөрийн нийт дүнд харьцуулна. Энэ нь тухайн салбараас бусад салбаруудад нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийн бүтцийг харуулна.

$$o_{ij} = \frac{x_{ij}}{X_i} \quad (2)$$

Маш олон бодлогын арга хэмжээнд эдгээр коэффициентийг ашигладаг. Тухайлбал, Засгийн газрын зүгээс зардлын хяналтыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нөхцөлд дээрх 2 коэффициентийг ашиглаж болно.

Леонтьевийн урвуу матриц (Leontief inverse matrix) гэдэг нь ямар нэг салбарт 1 нэгж эцсийн хэрэглээ бий болоход бусад салбаруудад хэдийн хэмжээний үйлдвэрлэлийн үр ашиг бий болгохыг харуулдаг матриц бөгөөд салбар хоорондын тэнцлийн шинжилгээний цөм нь юм.

Леонтьевийн урвуу матрицыг мөрийн дагуух эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг нийт үйлдвэрлэлт X -н хувьд дараах байдлаар тооцож харуулъя.

$$AX + F = X$$

$$(I - A)X = F$$

Энд A нь шууд зардлын буюу орцын матриц юм
Үйлдвэрлэлийн тэнцвэрийн загвар:

$$X = (I - A)^{-1} F \quad (3)$$

X -нийт гаргалт, $(I - A)^{-1}$ - Леонтьевийн урвуу матриц, F - эцсийн хэрэглээ, энд I - нэгж матриц байна. 2 салбар бүхий үйлдвэрлэл зардлын хүснэгтийн хувьд нэгж матриц нь дараах хэлбэртэй байна.

$$I = \begin{pmatrix} 1 & 0 \\ 0 & 1 \end{pmatrix}$$

$(I - A)^{-1}$ гэсэн Леонтьевийн урвуу матриц бүхий тэгшитгэл (3)-г үйлдвэрлэлийн тэнцвэрийн загвар гэдэг. Энэ загварыг ашиглан, дурын эцсийн хэрэглээ F нь эгзоген хэлбэрээр өгөгдсөн үед эрэлтэд шууд болон шууд бусаар шаардлагатай үйлдвэрлэлийн хэмжээ X -г тооцох боломжтой юм.

Хэрэв Леонтьевийн урвуу матриц B -г дараах хэлбэрээр бичвэл:

$$B = \begin{pmatrix} b_{11} & b_{21} \\ b_{12} & b_{22} \end{pmatrix} \quad (4)$$

b_{ij} нь j -р салбарын эцсийн хэрэглээ 1 нэгжээр нэмэгдсэн тохиолдолд эцсийн хэрэглээний өсөлт эсвэл эцсийн хэрэглээгээр дамжсан завсрын хэрэглээ өсөлтөөс шалтгаалан, i салбарын үйлдвэрлэл нь хэдэн нэгжээр нэмэгдэхийг харуулна. Жишээ нь: ХАА болон АҮ гэсэн хоёр салбартай байг. Леонтьевийн урвуу матриц B -г баганын дагуу харвал b_{11} нь ХАА дахь эцсийн хэрэглээг илэрхийлэх бол энэ нь 1 нэгжээр нэмэгдэхэд ХАА-н үйлдвэрлэл шууд болон шууд бусаар хэдэн нэгжээр өсөхийг, b_{21} нь энэ тохиолдолд аж үйлдвэрийн үйлдвэрлэл шууд бусаар хэдэн нэгжээр өсөхийг харуулж байна. Үүнтэй адилаар, b_{12} нь аж үйлдвэр дэх эцсийн хэрэглээ 1 нэгжээр нэмэгдэхэд ХАА-н үйлдвэрлэл шууд бусаар хэдэн нэгжээр өсөхийг, b_{22} нь энэ тохиолдолд аж үйлдвэрийн үйлдвэрлэл шууд болон шууд бусаар хэдэн нэгжээр өсөхийг харуулна.

Гэхдээ Леонтьевийн урвуу матрицын диагоналийн элементүүд (жишээ нь b_{11} , b_{22}) нь ямагт 1-с их утга авах бол бусад элементүүд нь 1-с бага байдаг. Өөрийн салбар дахь эцсийн хэрэглээ шууд 1 нэгж, түүн дээр эцсийн хэрэглээгээр дамжсан завсрын хэрэглээ нэмэгдэх тул диагоналийн элемент b_{ij} нь мэдээж 1-с их болно.

Үйлдвэрлэлийн үржүүлэгч: Леонтьевийн урвуу матрицыг үйлдвэрлэлийн өөрчлөлтөөр үржүүлэх замаар тодорхойлох бөгөөд энэ нь аль нэг салбарын эцсийн хэрэглээ 1 нэгжээр нэмэгдэхэд тухайн салбар болон бусад салбарын үйлдвэрлэл нийлээд хэдий хэмжээтэй нэмэгдэхийг харуулдаг.

Хөдөлмөрийн үржүүлэгч: Хөдөлмөрийн үржүүлэгчийг тооцохдоо салбар тус бүрийн нийт үйлдвэрлэлийг тухайн салбарын ажиллагчдын тоонд харьцуулснаар хөдөлмөрийн коэффициентийг гаргаж авна. Энэ коэффициентийг Леонтьевийн урвуу матрицаас тооцсон үйлдвэрлэлийн үржүүлэгчийн матрицын үржвэрээс тодорхойлдог.

Тоон өгөгдөл: Нөхцөл байдлын шинжилгээнд ашигласан өгөгдлийг ҮСХ-оос гаргадаг эдийн засгийн салбараарх ДНБ-ий тоо мэдээг авч ашиглалаа.

Үржүүлэгчийн шинжилгээг Азийн хөгжлийн банкны сайтад байршуулсан Монгол Улсын 2022 оны Салбар хоорондын тэнцлийн тоо мэдээг ашиглаж гүйцэтгэсэн болно. Уг тооцооллын суурь нь ҮСХ-оос 2019 онд гаргасан салбар хоорондын тэнцэл бөгөөд тодорхой аргачлалын дагуу 2022 оны салбар хоорондын тэнцлийг прогнолох байдлаар байгуулсан үр дүн юм.

Хэдийгээр уг салбар хоорондын тэнцлийг 35 салбараар байгуулсан боловч ҮСХ-оос гаргадаг ажиллах хүчний салбаруудын ялгаатай байдлаас үүдэн хөдөлмөрийн үржүүлэгчийг ашиглан тооцоолол хийхэд 17 салбар болгон нэгтгэсэн болно.

Эмпирик шинжилгээний үр дүн

Эмпирик шинжилгээг хийхдээ Санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал болон Салбар хоорондын тэнцлийн шинжилгээг ашиглан санхүүгийн салбарын эцсийн хэрэглээний үржүүлэгчийн нөлөө гэсэн хоёр хэсгээр авч үзлээ.

Санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл

Санхүүгийн салбарын нэмэгдсэн өртөг 2024 онд оны үнээр 4.25 их наяд төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2 их наяд төгрөг болсон байна. Өмнөх онтой харьцуулахад салбарын өсөлт 2024 онд 26.1 хувьд хүрсэн нь хамгийн өндөр өсөлттэй салбар болжээ.

Хүснэгт 2. Салбаруудын ДНБ-нд эзлэх хувь

	Эдийн засгийн салбар	Сүүлийн 5 жилийн дундаж	2024 он	Зөрүү
1	Хөдөө аж ахуй	11.15	7.25	-3.90
2	Уул уурхай, олборлолт	25.93	27.85	1.92
3	Боловсруулах үйлдвэрлэл	8.04	6.61	-1.43
4	Цахилгаан, хий, уур	1.73	1.45	-0.28
5	Усан хангамж; бохир ус, хог	0.53	0.53	0.00
6	Барилга	3.85	3.87	0.02
7	Бөөний болон жижиглэн худалдаа	16.56	18.21	1.65
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4.64	5.39	0.75
9	Зочид буудал, орон сууц, нийтийн хоол	1.11	1.29	0.18
10	Мэдээлэл, холбоо	2.27	2.26	-0.01
11	Санхүү, даатгалын үйл ажиллагаа	4.92	5.36	0.44
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4.76	4.5	-0.26
13	Мэргэжлийн, шинжлэх ухааны үйл ажиллагаа	1.56	1.65	0.09
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.78	0.86	0.08
15	Төрийн удирдлага	4.83	4.95	0.12
16	Боловсрол	4.16	4.52	0.36
17	Хүний эрүүл мэнд	2.31	2.41	0.10
18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.43	0.52	0.09
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.45	0.5	0.05
	Бүгд	100.00	100.00	0

Эх сурвалж: 1212.mn

Санхүүгийн салбарт 2024 оны байдлаар 30.5 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 2.25 хувь болж байгаа бол нэмэгдсэн өртөг нь нийт эдийн засгийн 5.36 хувийг бүрдүүлж байна. Энэ нь санхүүгийн салбар бусад салбаруудтай харьцуулахад хөдөлмөрийн бүтээмж өндөртэй байг илэрхийлж байна.

Манай улсын эдийн засагт Санхүүгийн салбар нь голлох нөлөөтэй салбар болж чадсан бөгөөд сүүлийн 5 жилийн дунджаар ДНБ-ий 4.92 хувийг бүрдүүлж байна.

Салбаруудын эдийн засагт эзлэх хувийн жингийн утгуудыг сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 2024 оны байдлаар Санхүүгийн салбар 0.44 нэгж хувиар илүү байгаа нь тэлэлт сайн байгааг илэрхийлж байна. Хамгийн өндөр тэлэлттэй салбар нь Уул уурхай, үүний дараа Бөөний болон жижиглэнгийн худалдаа, Тээвэр ба агуулах гэсэн дараалалтай байгаа бол Санхүүгийн салбар 4-д эрэмбэлэгдэж байна. Хэдийгээр хөдөө аж ахуй манай улсын эдийн засгийн нэг чухал салбар боловч сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын эрчимтэй тэлэлтийн нөлөөгөөр хувийн жин буурсаар байна. Мөн байгаль, цаг уурын нөлөөлөл өндөр байдаг нь үйлдвэрлэлийн өсөлт, бууралтын зөрүү ихтэй байхад хүргэдэг.

2024 онд хамгийн их тэлэлттэй гарсан 4 салбарын өсөлтийн хувийг сүүлийн 10 жил буюу 2015-2024 оны байдлаар хэрхэн өөрчлөгдсөн бэ гэдгийг харьцуулан авч үзлээ.

Зураг 1. Эдийн засгийн хувьд тэлэлт өндөр салбаруудын өсөлтийн хувь



Эх сурвалж: 1212.mn

Зургаас харвал тэлэлт өндөртэй 4 салбараас Санхүүгийн салбар л эдийн засгийн нөхцөл байдал тааруу байсан Ковид-19 цар тахлын үе болох 2020 онд эерэг гарч байжээ. Бусад салбарын хувьд зарим жилүүдэд өсөлттэй гарч байгаа бол зарим жилүүдэд уналттай гарах зэргээр хэлбэлзэл өндөртэй явж ирсэн байна.

Санхүүгийн салбарын хувьд сүүлийн 10 жилд жилийн дундаж өсөлт нь 11 хувьтай байгаа бол 2024 онд 26.1 хувийн өсөлтийг үзүүлсэн нь дунджаасаа 15.1 нэгж хувиар

өндөр гарсан онцгой тохиолдол болжээ. Улсын дунджаар жилийн дундаж өсөлт 3.68 хувь байхад Санхүүгийн салбарынх 11 хувьтай гарсан нь салбарын өсөлт сайн байгааг илэрхийлж байна.

Санхүүгийн салбарын үржүүлэгчийн нөлөө

Улс оронд хэрэгжүүлж байгаа бодлогын үр дүнг эдийн засгийн салбаруудад үзүүлсэн нөлөөллөөр хамгийн сайн тодорхойлон харуулах боломжтой арга зүй бол Салбар хоорондын тэнцэл байдаг. Сүүлийн жилүүдэд манайд хийгдэж байгаа томоохон судалгаануудад уг арга зүйг ашиглан эдийн засгийн салбаруудад үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, бодлого шийдвэр гаргалтад ашиглах нь эрчимжиж байна.

Тухайн салбарын эцсийн эрэлт 1 төгрөгөөр нэмэгдэхэд тухайн салбартаа болон бусад салбарт хэдий хэмжээний үр ашиг бий болохыг харуулах боломжтой юм. Энэхүү үржүүлэгчийг тооцоход шууд зардлын коэффициентын матрицыг байгуулж, уг матрицаа ашиглан урваа матриц тооцох замаар шууд үржүүлэгчийн нөлөөг тодорхойлдог. Уг тооцоог нийт улсын хэмжээнд хийж Санхүүгийн салбарын үржүүлэгчийн нөлөөг тооцож үзэхэд 1.07 гарсан. Үүнийг ашиглан Санхүүгийн салбарын бий болгосон нэмэгдэл өртөг нь эцсийн хэрэглээг илэрхийлж, бусад салбаруудад нөлөөлнө гэж үзэн Ковид-19 цар тахлын үеийг илэрхийлсэн хамгийн бага өсөлттэй 2020 он болон санхүүгийн салбарын хамгийн өндөр өсөлттэй гарсан 2024 оноор тус тус үржүүлэгчийн нөлөөг тооцож үзлээ.

Хүснэгт 3. Санхүүгийн салбарын нэмэгдсэн өртгийн үржүүлэгчийн нөлөө / тэрбум төгрөг/

	Салбарууд	2020	2024
	Санхүүгийн салбарын нэмэгдсэн өртгийн дүн /тэрбум төгрөг/	1690	4286
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	9.9	25.0
2	Уул уурхай, олборлолт	6.6	16.6
3	Боловсруулах үйлдвэрлэл	30.3	76.8
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	46.4	117.7
5	Барилга	46.1	116.8
6	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	29.4	74.5
7	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	17.0	43.2
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	15.8	40.1

9	Мэдээлэл, холбоо	67.1	170.1
10	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1810.6	4591.8
11	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	56.2	142.5
12	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	76.4	193.7
13	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1.1	2.9
14	Боловсрол	4.4	11.3
15	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.6	1.4
16	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	2.2	5.6
17	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.0	0.0
	Нийт дүн	2220.0	5630.0

Эх сурвалж: 1212.тп, Судлаачийн тоо

Санхүүгийн салбарын нийт нэмэгдэл өртөг 2020 онд 1.69 их наяд төгрөг байна. Тооцооноос харвал санхүүгийн салбарт бий болгож буй эцсийн эрэлт Санхүүгийн салбартаа 1.8 их наяд төгрөг, бусад салбарт 409.5 тэрбум нийт 2.22 их наяд төгрөгийн эцсийн хэрэглээг бий болгожээ. Харин 2024 онд 4.28 их наяд төгрөг болсон нь Санхүүгийн салбартаа 4.59 их наяд төгрөг, бусад салбарт 1 их наяд төгрөг, нийт 5.6 их наяд төгрөгийн эцсийн хэрэглээг бий болгосон байна.

Санхүүгийн салбар нь өөртөө үзүүлэх нөлөө хамгийн өндөр бөгөөд бусад салбарт үзүүлэх нөлөөг харвал Мэргэжлийн болон шинжлэх ухаан техникийн салбар 2-д эрэмбэлэгдэж байгаа ба 2024 онд 193.7 тэрбум төгрөг үйлдвэрлэлийн үр ашгийг бий болгосон бол Үл хөдлөх хөрөнгийн салбар 142.5 тэрбум төгрөгөөр 3-рт эрэмбэлэгдэж байна.

Дээрхээс гадна Sun(2022)-д дурдсан Partial Extraction Technique аргыг ашиглан Санхүүгийн салбарын нийт үйлдвэрлэлтийг 50 хувиар бууруулж тооцоог хийж үзэхэд манай улсын одоогийн нөхцөл байдалд эдийн засгийн агшилт 2 хувь байхаар тооцоо гарсан.

Хөдөлмөрийн үржүүлэгчийн нөлөө: Салбар хоорондын тэнцэлд тулгуурлан тухайн салбар дахь эцсийн хэрэглээний түвшинг ашиглан улсын хэмжээнд хэдий хэмжээний ажлын байрыг шинээр бий болгох боломжтой талаар энэ хэсэгт тооцоог хийлээ.

Тооцоонд нэмэлтээр ҮСХ-оос гаргасан ажиллах хүчний статистик мэдээг ашиглаж, Санхүүгийн салбарын нэмэгдсэн өртгөөр дамжин шууд бий болсон болон бусад салбарт шууд бусаар бий болсон ажлын байрыг өмнөх тооцоотой адилаар 2020 болон 2024

оноор гаргав. Энд түр болон байнгын ажлын байрыг бүхэлд нь багтаасан гэж үзэж тооцооллыг хийсэн болно.

Хүснэгтийн үр дүнгээс харвал Санхүүгийн салбараар дамжин бий болгосон эцсийн хэрэглээ нь Санхүүгийн салбартаа шууд байдлаар 2020 онд 41'083, 2024 онд 105'929 түр болон байнгын ажлын байрыг бий болгосон бол бусад салбарт шууд бусаар 2020 онд 10'436, 2024 онд 32'910 түр болон байнгын ажлын байрыг бий болгожээ.

Хүснэгт 4. Санхүүгийн салбарын нэмэгдсэн өртгийн хөдөлмөрийн үржүүлэгчийн нөлөө

	Салбарууд	2020	2024
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	938	2061
2	Уул уурхай, олборлолт	35	124
3	Боловсруулах үйлдвэрлэл	598	1758
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	845	2972
5	Барилга	1070	3144
6	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	1639	4901
7	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	943	3569
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	458	1457
9	Мэдээлэл, холбоо	1926	5902
10	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	41083	105929
11	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	164	672
12	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1120	4289
13	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	92	250
14	Боловсрол	520	1574
15	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	41	105
16	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	47	132
17	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0	0
	Нийт дүн	51519	138839

Эх сурвалж: 1212.тп, Судлаачийн тоо

Нийт дүнгээр авч үзвэл Санхүүгийн салбараар дамжин бий болсон эцсийн хэрэглээ нь шууд болон шууд бусаар 2020, 2024 онуудад харгалзан 51'519, 138'839 ажлын байрыг бий болгожээ. Дүгнэж үзвэл эдийн засаг эрчимтэй тэлснээр 2020 онтой харьцуулахад бий болсон түр болон байнгын ажлын байр 2024 онд 2.69 дахин нэмэгдсэн болох нь харагдаж байна.

Дүгнэлт

Манай улсын эдийн засаг эрчимтэй тэлэхийн хэрээр Санхүүгийн салбар ч эрчимтэй тэлж байна. Энэхүү эрчимтэй тэлэлтийн үр нөлөө бусад салбарт хангалттай хэмжээнд нөлөөлж чадаж байна уу, чадаж байгаа бол хэдий хэмжээтэйгээр нөлөөлж байна гэдгийг тодорхойлон харуулж чадвал цаашид бодлого гаргах, түүнийгээ хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй юм.

Санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг Салбар хоорондын тэнцлийн нөлөөллийг ашиглан тодорхойлсон бөгөөд олон улсад энэ чиглэлээр хийгдсэн судалгаа нэлээд байна.

Санхүүгийн салбарын нэмэгдсэн өртөг 2024 онд оны үнээр 4.25 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2 их наяд төгрөгт хүрээд байна. Эдийн засгийн салбаруудад эзлэх хувийн жингийн тооцооноос харвал Санхүүгийн салбар 5.36 хувь байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 0.44 нэгж хувиар илүү байгаа нь бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй өндөр дүн юм. Өмнөх онтой харьцуулахад 26.1 хувиар өссөн нь салбарууд дотроо хамгийн өндөр өсөлттэй салбар болсон байгаа нь цаашид ч өсөх эерэг хүлээлтийг бий болгож байна.

Салбар хоорондын шинжилгээний үр дүнгээс харвал Санхүүгийн салбарын эцсийн хэрэглээний шууд үржүүлэгчийн нөлөө 1.07 гарсан нь Цахилгаан, Боловсруулах, Барилга гэсэн салбаруудын дараа орохоор үр дүн юм.

Санхүүгийн салбарын нийт нэмэгдэл өртөг 2020 онд 1.69 их наяд төгрөг байна. Тооцооноос харвал санхүүгийн салбарт бий болгож буй эцсийн эрэлт Санхүүгийн салбартаа 1.8 их наяд төгрөг, бусад салбарт 409.5 тэрбум нийт 2.22 их наяд төгрөгийн эцсийн хэрэглээг бий болгожээ. Харин 2024 онд 4.28 их наяд төгрөг болсон нь Санхүүгийн салбартаа 4.59 их наяд төгрөг, бусад салбарт 1 их наяд төгрөг, нийт 5.6 их наяд төгрөгийн эцсийн хэрэглээг бий болгосон байна.

Хөдөлмөрийн үржүүлэгчийн коэффициентыг ашигласан тооцоогоор Санхүүгийн салбараар дамжин бий болсон эцсийн хэрэглээ нь шууд болон шууд бусаар 2020, 2024 онуудад харгалзан 51'519, 138'839 ажлын байрыг бий болгожээ. Эдийн засаг эрчимтэй тэлснээр 2020 онтой харьцуулахад бий болсон түр болон байнгын ажлын байр 2024 онд 2.69 дахин нэмэгдсэн болох нь харагдаж байна.

Дүгнэж хэлэхэд салбар хоорондын тэнцлийн тооцооноос Санхүүгийн салбар нь эдийн засагт голлох салбар болж чадсан бөгөөд бий болсон нэмэгдэл өртөг нь эцсийн хэрэглээгээр дамжаад бусад салбаруудад үзүүлэх нөлөө өндөр байна гэдэг үр дүнд хүрлээ.

Эдийн засгийн нөхцөл байдлаас харвал бусад салбарууд хямралд өртөмтгий байдал өндөртэй, хэлбэлзэл ихтэй байгаа бол Санхүүгийн салбар хямралд өртөх байдал харьцангуй бага, байнгын өсөлттэй явж иржээ.

Санхүүгийн салбарыг задалж харвал банк, даатгал, хөрөнгийн зах зээлтэй холбоотой судалгааны ажлууд нэлээд хийгдэж байгаа боловч тусгайлан макро түвшинд уг салбар маань ямар нөлөө үзүүлж байгаа талаарх ажлууд хомс байна. Цаашид энэ дутагдлыг арилгах зорилгоор макро загварыг ашиглан Санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлж

буй нөлөөллийг судлах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй байна.

Цаашид макро түвшинд салбар хоорондын тэнцлийн болон бусад макро загваруудыг ашиглан санхүүгийн салбарын шууд болон дам нөлөөллийг тогтмол хэмждэг тогтолцоог бий болгох, судалгааны үр дүнг бодлогын шийдвэр гаргахад ашигладаг байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байна. Нөгөөтэйгүүр банк, даатгал, хөрөнгийн зээлийн дэд салбаруудын тэнцвэртэй өсөлтийг хангах бодлого боловсруулах, хямралд өртөмтгий бус, тогтвортой өсөлттэй байгаа давуу талыг ашиглан эдийн засгийг тогтворжуулагч механизм болгон хөгжүүлэх нь зүйтэй байна. Санхүүгийн салбарын эцсийн хэрэглээний үржүүлэгчийн нөлөө бусад салбаруудад илүү хүчтэй нөлөө үзүүлдэг болохын тулд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үржүүлэгчийн нөлөө өндөртэй барилга, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, уул уурхайн салбаруудтай уялдуулах бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Ашигласан материал

- Bunse, J., & Finkbeiner, M. (2023). An Introductory Review of Input-Output Analysis in Sustainability Sciences Including Potential Implications of Aggregation. *Sustainability*, 15(1).
- Leontief, W. (1986). *Input-Output Economics*. Oxford University Press.
- Malik, A., & Schaeffer, R. (2024). Integrated assessment modelling and input-output analysis for financial sector impacts. *Journal of Economic Modelling*.
- OECD (2023). *Input-Output Analysis in an Increasingly Globalised World*. OECD Publications.
- Sun, T. (2022). Systemic importance of financial services and insurance sectors: a world input-output network analysis. Springer.
- N. Tungalag, B. Unenbat, L. Oyuntsetseg, & R. Enkhbat (2019), Application of Input-Output Table for Structural Analysis of the Nation's Economy: A Case of Mongolia, *Advances in Economics and Business*, Vol 7(6), pp. 266 – 270.
- АХБ (2023) цахим хуудас Input-Output table (<https://data.adb.org/dataset/mongolia-input-output-economic-indicators>)
- ҮСХ-ны цахим хуудас 1212.mn
- МУИС-ЭЗХ (2018) Оюутолгой төслийн монголын хөгжилд үзүүлж буй нөлөөллийн судалгаа Төслийн тайлан
- МУИС-ЭЗХ (2021) Ковид-19 цар тахлын үед Оюутолгойн монгол улсын нийгэм эдийн засагт үзүүлсэн нөлөө Төслийн тайлан
- Ц.Тэгшжаргал, Ц.Бямбацогт, & О.Цолмон (2022) Салбар хоорондын тэнцэл: ерөнхий ойлголт, хэрэглээ, шинжилгээ Монголбанкны судалгааны товхимол
- Б.Үнэнбат, С.Батбилэг, & З.Баттуяа. (2023). Цахилгаан эрчим хүчний салбарын бусад салбарт үзүүлэх нөлөө. *Journal of Business and Innovation (Бизнес & Инноваци)*, 6(1), 87–99.
- Б.Цогт-Эрдэнэ (2009) Монгол улсын салбар хоорондын баланс дахь шинжилгээ Эдийн засаг: Онол, практик pp 25-41